

# **ХҮНД ҮЙЛДВЭРИЙН ҮЙЛДВЭРЛЭЛ, ТЕХНОЛОГИЙН ПАРКИЙН МЭДЭЭЛЛИЙН САН БҮРДҮҮЛЭХ, ХӨТЛӨХ ЖУРАМ**

## **Нэг. Нийтлэг үндэслэл**

- 1.1. Энэ журмын зорилго нь дэвшилтэт техник, технологийн судалгаа хийх, бүтээгдэхүүн үйлчилгээний үнэ, эрэлт хэрэгцээний хэтийн төлөвийг тодорхойлох хүрээнд судалгаа, тооцоо хийхэд шаардлагатай хүнд үйлдвэрийн үйлдвэрлэл, технологийн паркийн мэдээллийн сан /цаашид “паркийн мэдээллийн сан” гэх/-г үүсгэх, хөтлөхтэй харилцааг зохицуулахад оршино.
- 1.2. Паркийн мэдээллийн санг бүрдүүлэх, хөтлөхтэй холбогдсон үйл ажиллагаанд Үйлдвэрлэл, технологийн паркийн эрх зүйн байдлын тухай хууль, Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хууль, Төрийн нууцын тухай хууль болон бусад холбогдох хууль тогтоомж энэ журмыг дагаж мөрдөнө.
- 1.3. Паркийн мэдээллийн санг цахим хэлбэрээр бүрдүүлэх ба мэдээлэл нь тоон өгөгдөл, зураг, график, бичгийн болон бусад хэлбэртэй байна.
- 1.4. Энэ журам нь нэг талаас хүнд үйлдвэрийн үйлдвэрлэл, технологийн паркт үйл ажиллагаа эрхэлж байгаа хуулийн этгээд, эрдэм шинжилгээний байгууллага, төрийн ба төрийн бус байгууллага, иргэн, нөгөө талаас паркийн мэдээллийн санг эрхлэх байгууллагын хооронд үүсэх харилцаанд үйлчлэх бөгөөд энэ журмын 2.1-т заасан мэдээллээр үйлчилнэ.

## **Хоёр. Паркийн мэдээллийн сангийн бүрэлдэхүүн**

2.1. Мэдээллийн сан дараах бүрэлдэхүүнтэй байна:

2.1.1. Холбогдох олон улсын конвенц, баримт бичиг;

2.1.2. Хууль, тогтоомж;

2.1.3. Стандарт, норм, норматив, маягтууд;

2.1.4. Паркийн хөгжлийн төлөвлөгөө;

2.1.5. Бүтэц зохион байгуулалт;

2.1.6. Паркийн хөгжлийн чиг хандлагын судалгаа, тайлан;

2.1.7. Паркт үйлдвэрлэсэн бүтээгдэхүүний үндсэн төрлүүд, үйлдвэрлэл, борлуулалт, экспорт, импортын хэмжээ;

2.1.8. Паркийн бүтээгдэхүүн, үйлчилгээний үнэ, эрэлт хэрэгцээний хэтийн төлөвийн талаарх судалгаа, мэдээлэл;

2.1.9. Хүнд үйлдвэрт ашиглагдаж байгаа өндөр үр ашиг бүхий дэвшилтэт техник, технологийн мэдээлэл;

2.1.10. Хүнд үйлдвэрийн паркийн чиглэлээр хэрэгжүүлж байгаа төсөл, хөтөлбөр, хүнд үйлдвэрийн паркийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл эзэмшигчийн мэдээлэл;

2.1.11. Төрөөс дэмжлэг авсан паркийн удирдлага, нэгжүүд болон дэмжлэгийн үр дүн, үзүүлэлт;

2.1.12. Хүнд үйлдвэрийн парк дахь хүний нөөц, боловсон хүчний хэрэгцээг тооцсон хүйсээр ангилсан мэдээлэл;

2.1.13. Эрдэм шинжилгээ, судалгааны тайлан, бүтээлүүд,

2.1.14. Холбогдох бусад мэдээлэл.

### **Гурав. Паркийн мэдээллийн санг бүрдүүлэх, хөтлөх**

3.1. Хүнд үйлдвэрийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага /цаашид “төрийн захиргааны төв байгууллага” гэх/ нь паркийн мэдээллийн сангийн үйл ажиллагааг эрхэлж, удирдан зохион байгуулна.

3.3. Паркийн мэдээллийн санг нь нээлттэй мэдээллээс бүрдэнэ.

### **Дөрөв. Мэдээллийн санг хөтлөх байгууллагын эрх, үүрэг**

4.1. Хүнд үйлдвэрийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага нь дараах эрх, үүрэгтэй. Үүнд:

- 4.2.1. Паркийн мэдээллийн санд шаардлагатай программ хангамж, компьютер, тоног төхөөрөмжийг худалдан авахад шаардагдах хөрөнгийн эх үүсвэрийг жил бүрийн улсын төсөвт тусгуулах;
- 4.2.2. Паркийн удирдлага, нэгжээс холбогдох мэдээллийг гаргуулж авах;
- 4.2.3. Паркийн мэдээллийн санг боловсронгуй болгох чиглэлээр олон улсын туршлага судлах болон холбогдох асуудлаар олон улсын байгууллагатай хамтран ажиллах;
- 4.2.4. Хэрэглэгчдийг үнэн зөв, тухайн цаг үеийн шаардлагад нийцсэн мэдээллээр хангах;
- 4.2.5. Мэдээллийг тогтмол шинэчлэн баяжуулах;
- 4.2.6. Паркийн удирдлага, нэгжид тэдний хүсэлтийн дагуу шаардлагатай мэдээллийг гаргаж өгөх;
- 4.2.7. Дотоод, гадаад сүлжээ болон компьютер, тоног төхөөрөмжийн аюулгүй байдлыг хангах;
- 4.2.8. Нууцын зэрэглэлд хамаарах мэдээлэл болон паркийн мэдээллийн сангийн бүрэн бүтэн байдлыг чандлан хамгаалах.

## **Тав. Паркийн мэдээллийн сангийн хэрэглэгчийн эрх, үүрэг**

5.1. Паркийн мэдээллийн сангийн хэрэглэгч нь дараах эрх, үүрэгтэй. Үүнд:

- 5.2.1. Нээлтэй мэдээлийн сангаас мэдээлэл авах;
- 5.2.2. Мэдээлэлтэй холбогдсон асуудлаар бичгээр хүсэлт гарган нэмэлт тайлбар авах, тодруулах.
- 5.2.3. Мэдээлэл авах эрхээ хэрэгжүүлэхдээ Монгол Улсын Үндсэн хууль болон бусад хуулиар хамгаалагдсан бусдын эрх, хууль ёсны ашиг сонирхлыг зөрчихгүй байх;
- 5.2.4. Паркийн мэдээллийн сангийн мэдээллийг ашигласан тохиолдолд эх сурвалжийг заавал дурдах;
- 5.2.5. Нууцын зэрэглэлд хамаарах мэдээллийг гуравдагч этгээдэд задруулахгүй байх.

## **Зургаа. Хүлээлгэх хариуцлага**

6.1. Энэ журмыг зөрчсөн иргэн, албан тушаалтан, хуулийн этгээдэд Эрүүгийн хууль, Төрийн албаны тухай хууль, Зөрчлийн тухай хууль болон холбогдох бусад хуульд заасан хариуцлага хүлээлгэнэ.

--oOo--